

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 02 дугаар сарын 01-ний  
өдрийн 30 дугаар тогтоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО,  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	
			Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага
1	2	3	4	5
Нэг. Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах стратегийн зорилтын хүрээнд				
1.1	<a href="#">Иргэдэд түшиглэсэн гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлэх</a>	2013-2020	ОБЕГ	Аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын байгууллага
1.2	Сумын түвшинд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төрийн захиргааны албан хаагчийг ажиллуулах	2012-2013	ОБЕГ	ЗГХЭГ
1.3	Төв, орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллага, түүнчлэн хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах арга хэмжээнд оролцох оролцоог нэмэгдүүлж, түншлэл, хамтын ажиллагаа, салбар дундын удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох	2012-2015	ОБЕГ	Гамшгаас хамгаалах улсын албад
1.4	Болзошгүй гамшгийн аюулыг бууруулах арга хэмжээнд олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх	2015-2020	ОБЕГ	Аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын байгууллага
1.5	Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлын улсын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	2012-2013	ОБЕГ	Гамшгаас хамгаалах улсын албад
1.6	Төв, орон нутгийн томилгоот гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг тогтоох	2013-2014	ОБЕГ	
1.7	Гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг гамшгаас хамгаалах арга хэмжээнд нэвтрүүлэх	2012-2020	ОБЕГ	Шинжлэх ухааны байгууллага
1.8	Төв, орон нутгийн төрийн байгууллага, хувийн хэвшлийн	2012-2020	ОБЕГ	Гамшгаас хамгаалах

	гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлж, гамшгийн бэлэн байдлыг хангахад шаардлагатай эд материал, аврах багаж, техник хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх			улсын албад, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өндөр настан зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагыг хангасан бэлэн байдлын тусгай хөтөлбөрийг боловсруулах	2013-2014	ОБЕГ	НХХЯ
1.10	Мэргэжлийн байгууллагын бие бүрэлдэхүүн, дайчилгаагаар ажилласан байгууллагын хүн хүч, ард иргэдийн гамшгийн дараахь сэтгэл зүйн хямралыг багасгах, арилгах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бий болгох	2013-2016	ОБЕГ	ЭМЯ
1.11	Хилийн боомт болон хилийн зурвас газарт үүсч болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед түүний хор уршгийг арилгах чиглэлээр мэргэжлийн байгууллага, нутгийн захиргааны байгууллага хоорондын харилцан ажиллагааг төлөвлөх, багаж хэрэгслийн хангамжийг сайжруулах	2015-2020	ХХЕГ	ОБЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.12	Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хөрш орон, гол хандивлагч түнш орнууд болон олон улсын байгууллагуудтай хоёр болон олон талын шугамаар хамтран ажиллах	2012-2020	ОБЕГ	ГХЯ
1.13	“Аюулгүй эмнэлэг” үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2013-2015	ЭМЯ	
Хоёр. Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах стратегийн зорилтын хүрээнд				
2.1	Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх	2012-2016	ОБЕГ	Гамшгаас хамгаалах улсын албад, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ
2.2	Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг учруулж болзошгүй байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн аюул, төв, орон нутгийн газар зүйн байршил, эдийн засаг, нийгмийн онцлог, хөгжлийн бодлого, олон улсын жишиг үнэлгээний аргачлалд тулгуурлан боловсронгуй болгох	2012-2015	ОБЕГ	Гамшгаас хамгаалах улсын албад, олон улсын байгууллага
2.3	Болзошгүй гамшгийн эрсдэл, түүний нөлөөллийн талаархи статистикийн мэдээ, өгөгдөхүүнийг цуглуулах стандартыг тогтоох, гамшгийн мэдээллийн сангийн үйлчилгээг	2012-2013	ОБЕГ	БОАЖЯ, СХЗГ

	боловсронгуй болгох			
2.4	Бүс нутгийн болон хил дамнасан болзошгүй гамшгийн эрсдэлийг үнэлэх, байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу мэдээлэл солилцох	2013-2015	ОБЕГ	Аймаг, нийслэлийн Засаг дарга
2.5	Гамшгаас хамгаалах талаархи иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, ардын уламжлалт арга ухааныг түгээн дэлгэрүүлэх	2012-2020	ОБЕГ	БСШУЯ
2.6	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийн менежментийн үндэсний дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	2012-2013	ОБЕГ	
2.7	Жил бүр 2 аймаг, 1 дүүрэгт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг, 3 аймаг, 1-2 гамшгаас хамгаалах улсын албанд команд штабын сургуулийг зохион байгуулах	2012-2020	ОБЕГ	Аймаг, нийслэлийн Засаг дарга
2.8	НҮБ-ын Хүмүүнлэгийн хэргийг зохицуулах албатай хамтран Хотын дотор эрэн хайх, аврах ажиллагааны олон улсын дадлага сургуулийг зохион байгуулах	2014	ОБЕГ	Гамшгаас хамгаалах улсын албад
2.9	Ерөнхий боловсролын сургуулийн “Иргэний боловсрол” хичээлийн сургалтын хөтөлбөрт гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаархи ерөнхий агуулгыг тусгах	2012-2013	БШСУЯ	
2.10	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн орон сууц, үйлчилгээний барилга, байгууламжийн эрсдэлийн үнэлгээ хийх	2013-2017	БСШУЯ, ЗТБХБЯ, ЭМЯ	ОБЕГ, гамшгаас хамгаалах улсын албад
2.11	Гамшгаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн үед хүн амыг нүүлгэн шилжүүлэх газар нутгийг Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, бэлтгэлийг хангах	2013-2015	Нийслэлийн Засаг дарга	
Гурав. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох стратегийн зорилтын хүрээнд				
3.1	Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2012-2015	ОБЕГ	НХХЯ, ГХЯ, СЗХ, даатгалын байгууллага
3.2	Галын аюулгүй байдлын дүрэм боловсруулах	2012	ОБЕГ	
3.3	Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны үндэсний хөтөлбөр боловсруулах	2012	ОБЕГ	
3.4	Тамперын конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлыг судлах	2012-2014	ОБЕГ	ГХЯ
3.5	Орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, захиран зарцуулах журам боловсруулж, батлуулах	2012-2013	ОБЕГ, ХХААХҮЯ	Аймаг, нийслэлийн Засаг дарга
Дөрөв. Аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологийг нэвтрүүлж,				

мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх арга замыг боловсруулж, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулах стратегийн зорилтын хүрээнд				
4.1	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зайнаас тандан судлах, газар зүйн мэдээллийн системийг нэвтрүүлэх	2012-2020	ОБЕГ	МШХХТГ
4.2	Эрсдэлийн зураглал, мэдээллийг боловсруулах, дамжуулах техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	2012-2014	ОБЕГ	ШУА
4.3	Болзошгүй гамшгийн аюулын талаар хүн амд түгээх зарлан мэдээллийн техник хэрэгслээр хангаж, мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх арга замыг боловсронгуй болгож, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулах	2013-2020	ОБЕГ	МШХХТГ
4.4	Онцгой байдлын албаны мэдээллийн техник болон программ хангамж, мэдээллийн сүлжээг орчин үеийн өндөр хурдны техник, технологиор өргөтгөх	2012-2016	ОБЕГ	МШХХТГ
4.5	Болзошгүй гамшгийн төрлүүдэд зохицон ажиллах өндөр боломж бүхий радио холбооны зангилгааг Онцгой байдлын албаны хэмжээнд байгуулах	2013-2015	ОБЕГ	МШХХТГ
4.6	Гамшгийн голомтод ажиллах мэдээлэл, холбооны удирдлагын хөдөлгөөнт зангилгааг орон нутагт байгуулах	2012-2016	ОБЕГ	МШХХТГ
Тав. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхийг бэхжүүлэх стратегийн зорилтын хүрээнд				
5.1	Аврагчийг мэргэжлийн сургалтын төвөөр бэлтгэх, мэргэшүүлэх	2012-2020	ОБЕГ	
5.2	Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох	2013-2020	ОБЕГ	БСШУЯ
5.3	Аврах, гал унтраах анги, бүлэг, бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай аврах ажлын багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тусгай зориулалтын машин механизмын стандарт, норм, нормативыг боловсруулах	2012-2014	ОБЕГ	СХЗГ
5.4	Эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй газар хөдлөлт, үер, цацраг, химийн хорт болон аюултай бодисын хордуулалт, бусад гамшгийн хор уршгийг арилгах аврах ажлын зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах	2012-2020	ОБЕГ	Олон улсын байгууллага
5.5	Аврах ажлын зарим багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх, засварлах төв байгуулах	2012-2020	ОБЕГ	
5.6	Улсын нөөцийн бараа, материалыг хадгалах нөхцөл, технологийг дээшлүүлэх	2012-2020	ОБЕГ	
5.7	Гамшгийн нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх,	2012-2020	ОБЕГ	ГХЯ

	зөвлөмж өгөх гамшгаас хамгаалах менежментийн үндэсний шинжээч болон гадаад улсад хүмүүнлэгийн үүрэг гүйцэтгэх аврах багийг бэлтгэх			
5.8	Гамшгаас хамгаалах улсын албадын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чадавхийг сайжруулах	2012-2020	Гамшгаас хамгаалах улсын албад	ОБЕГ
5.9	Болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, бүс нутгийн онцлог, хүн амын төвлөрөл, дэд бүтэц, эдийн засгийн хүчин зүйлийг харгалзан зарим аймагт аврах анги, салбар байгуулах	2012-2020	ОБЕГ	
5.10	Аврах, гал унтраах ангиудыг шинээр болон өргөтгөн зохион байгуулах	2012-2020	ОБЕГ	
5.11	Хүн амын төвлөрөл ихтэй томоохон хот, бүсийн төвд аврах “Шуурхай бүлэг” байгуулах	2013-2020	ОБЕГ	Аймаг, нийслэлийн Засаг дарга
5.12	Нийслэлийн ачаа тээврийн шалган нэвтрүүлэх товчоон дээр суурин ажиллагаатай ариутгалын цэг байгуулах	2015-2020	Нийслэлийн Засаг дарга	
5.13	Болзошгүй гамшгийн төрөл, бүс нутгийн онцлогт нийцүүлэн гамшгийн бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах чиглэлээр шаардлагатай мөнгөн хөрөнгө, бараа, материал, багаж, техник хэрэгслийн орон нутгийн болон Гамшгаас хамгаалах улсын албаны нөөц бүрдүүлэх	2013-2020	Гамшгаас хамгаалах улсын албад, аймаг, нийслэлийн Засаг дарга	
5.14	Аврагчийн бие бялдарын тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлэх хээрийн сургалтын төв байгуулах	2015-2020	ОБЕГ	СЯ